

ДеФакто **ТОЙМ**

**УИХ-ЫН ГИШҮҮДИЙН  
БҮРЭН ЭРХ**

**ОУВС БА МОНГОЛЫН  
ЭДИЙН ЗАСАГ**

**ХӨШИГТИЙН ХӨНДИЙН  
НИСЭХ БУУДАЛ**

**БОДЛОГЫН ХҮҮГ  
БУУРУУЛЖЭЭ**

VII НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

**ЭРЭГТЭЙ  
ХҮН ТУХГҮЙ  
ХУВЦАС**



ӨМССӨН БАЙВАЛ БИЕЭ  
БАРЬДАГ, ХӨЛӨРДӨГ, ЯМАР НЭГ  
ЗҮЙЛ ОРОЛДООД БАЙДАГ

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

**ДҮН**  
*Гарлаа*

Монголчууд бид эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож үндсэн хуулиндаа тунхаглаад хориод жил боллоо.

II НҮҮРТ

# The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2017.12.27, №27

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

# ДҮН *Гарлаа*







№ 411

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,  
<http://jargaldefacto.com/category/23>



# ДҮН *Гарлаа*

**М**онголчууд бид эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож үндсэн хуулиндаа тунхаглаад хориод жил боллоо. Улс орны хөгжлийн хэмжүүр бол иргэдийн элбэг хангалуун, энх тайван амьдрал билээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп сая зул сарын баярын хүслээ жиргэхдээ “Бидэнд элбэг хангалуун

амьдрал байна. Энх тайванг 2018 онд хүсэж байна” гэжээ. Монголд харин энх тайван нь бол байна, элбэг хангалуун амьдрал нь алга.

Энх тайван, элбэг хангалуун амьдралтай байхын тулд улс оронд ардчилал, чөлөөт зах зээл, шинэ бүтээл гэх гурван хүчин зүйл бүрдсэн байх учиртай. Энэ гурван хүчин зүйлийн хувьд монголчууд бид 2017 онд ямар өөрчлөлт, дэвшил гаргасан бэ?

## АРДЧИЛАЛ

Дэлхийн 167 орныг 60 үзүүлэлт, 10 хүртэл оноогоор дүгнэдэг The Economist сэтгүүлийн Ардчиллын индексээр Монгол улс 2014 - 2016 онуудад яг л нэг байрандаа буюу 6.62 оноогоор “гажигтай ардчилал” (flawed democracy) ангилалд гацжээ. Дэлхийн ардчиллын жагсаалтыг Норвеги улс сүүлийн таван жил 9.93 оноогоор тэргүүлж “төгс ардчилал” (full democracy) ангилалд байна. Харин Хойд Солонгос сүүлийн долоон жил (2010-2016) 1.08 оноогоор “дарангуйллын дэглэм” (authoritarian regime) ангилалд сүүл мушгиж байна.

<https://infographics.economist.com/2017/DemocracyIndex/>



## ЧӨЛӨӨТ ЗАХ ЗЭЭЛ

Монголчуудын гуравны нэг нь ядуу байна. Энэ оны 10-р сарын 17-нд зарласан Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банктай хамтран хийсэн судалгааны үр дүнд МУ-ын ядуурлын түвшин 29.6 хувьд буюу хүн амын бараг гуравны нэг ядуу байна. 2014 оны мөн судалгааны үр дүнтэй харьцуулахад энэ нь 37 хувиар өссөн үзүүлэлт. Өмнөговь аймагт ядуурал хамгийн бага буюу 15.4 хувь, Говьсүмбэр аймагт хамгийн өндөр буюу 52 хувьд хүрчээ.

Хэритэж Сангаас 2017 оны тайлангаар Монгол улс эдийн засгийн эрх чөлөөний индексээр 4.6 нэгжээр

буурч, 54.8 оноогоор 180 орноос 129-р байр эзэлж “эдийн засгийн эрх чөлөө багатай” ангилалд оржээ. Эдийн засгийн эрх чөлөөний жагсаалтыг Хонгконг 89.8 оноогоор тэргүүлж, Хойд Солонгос 4.9 оноогоор сүүл мушгижээ. <http://www.heritage.org/index/ranking>

Дэлхийн эдийн засгийн форумас гаргадаг Хүмүүний капитал индексээр 2017 онд Монгол улс 64.35 оноогоор 130 орноос 51-р байранд орсон. Энэ жагсаалтыг Норвеги 77.12 оноогоор тэргүүлж, Иемэн 35.48 оноогоор сүүл мушгижээ.

<https://weforum.ent.box.com/s/dari4dktg4jt2g9xo2o5pksjpatvawdb>

## ШИНЭ БҮТЭЭЛ

Дэлхийн ДНБ-ий 0.003 хувийг бүтээдэг Монгол улс 2017-2018 оны Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд 137 орноос 101-т жагссав. Тус тайлангийн 12 тулгуур үзүүлэлтээс 137-оос 65-д буюу хамгийн өндөрт жагссан нь “Дээд боловсрол, мэргэжлийн сургалт” байв. Харин сүүл мушгиж яваа буюу 137-оос 123-т жагссан үзүүлэлт нь “Бизнесийн боловсронгуй байдал”.

Инноваци буюу улсыг урагш түлхдэг гол үзүүлэлтээр Монгол улс 101-д жагсчээ. Сүүлийн 10 жилд МУ-ын өрсөлдөх чадварыг тус тайлангийн зэрэглэлээр дүгнэвэл нийт 7 оноогоос 3.6-3.9 онооны хооронд хэлбэлзсэн юм. Манай урд хөрш 5 оноогоор 27-д, хойд хөрш 4.64 оноогоор 38-д жагсаж байна.

Гэхдээ “МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигт бид 2030 он гэхэд өрсөлдөх чадвараараа дэлхийд эхний 70 орны нэг, харин бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр эхний 40 улсын нэг болох гэгээлэг зорилтыг тавиад байна.

Монголд бизнес эрхлэхэд хамгийн их асуудалтай хүчин зүйлсийн эхэнд гадаад валютын зохицуулалт, 2-рт авлига, 3-рт бодлогын тогтворгүй байдал, 4-рт нь засгийн газрын тогтворгүй байдлыг жагсаажээ.

Монголд үнэхээр энх тайван нь байна, элбэг хангалуун амьдрал харин алга.

2017.12.27





**Т.ЗОРИГ**

Примьер Тайлор компанийн  
үүсгэн байгуулагч

## ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

# ЭРЭГТЭЙ ХҮН ТУХГҮЙ ХУВЦАС ӨМССӨН БАЙВАЛ БИЕЭ БАРЬДАГ, ХӨЛӨРДӨГ, ЯМАР НЭГ ЗҮЙЛ ОРОЛДООД БАЙДАГ



*Т.Зориг АНУ-д суралцаж байсан ба 2012 онд компаниа байгуулж 2013 оны 7-р сард анхны дэлгүүрээ нээсэн. Анх байгуулагдахдаа зөвхөн тусгай захиалгын хувцас өөж байсан бол хоёр дахь жилээсээ эхлэн зөвхөн гар аргаар хувцас урлах технологийг нэвтрүүлсэн байна. Одоогоор эмэгтэй ажил хэрэгч хувцасны зах зээлд бүтээгдэхүүнээ танилцуулахаар ажиллаж байна.*

**Ж:** Эрэгтэй хүний ажил хэрэгч хувцасны тухай ярилцъя. Та энэ чиглэлээр Примьер Тайлор гэж компани байгуулаад 3 салбартай болчихлоо. Та яагаад Америкт маркетингаар сурч ирээд энэ зах зээлийг боломжтой гэж үзээд компаниа байгуулсан бэ?

**Т.Зориг:** Би багаасаа хувцас загварт сонирхолтой байсан. АНУ-д сурч байхдаа бусад гадаад оюутнуудтай нийлээд Европ оюутнуудад загварын зөвлөгөө өгдөг байлаа. Хэд хэдэн хичээлийн төслийг хувцас загварын брендүүд болон онлайн вебсайтууд дээр хийсэн. Монголд ирээд MCS Properties компанид маркетингийн чиглэлээр ажилд орж байхад хүн бүр оффисын хувцаслалт гэдэг утгаараа хослол өмсдөг байсан. Гэтэл монголд худалдан авах сонголт цөөхөн байдаг тул хэдхэн дэлгүүрээс очиж хослол авдаг, түүнийгээ оёдолчин дээр очиж янзлуулдаг, тэр нь чанарын өндөр түвшинд оёх уу гэдэг асуудалтай тулгарна. Таван жилийн өмнө Солонгос, Тайланд, Хонг Конг гэх мэт том улсуудад хослол захиалахад биеэс хэмжээ авах үйлчилгээ их дэлгэрч байсан тул үүнийг монголд нэвтрүүлэх гэж анх компаниа байгуулж байлаа.

**Ж:** Таван жилийн өмнө байгуулснаас хойш энэ үйлчилгээ амжилттай явж чадаж байна уу?

**Т.Зориг:** Би өөрийнхөө хийж байгаа ажлыг бизнес гэхээсээ илүү сонирхол гэж хардаг. Цаашдаа монголд ажил хэрэгч хувцасны соёлыг түгээх хүсэлтэй. Манай компани энэ салбартаа хамгийн том нь гэж хэлэхэд буруудахгүй байх. Гэхдээ эдийн засгийн хямралаас үүдэлтэйгээр бизнесийн үйл ажиллагаа явуулахад хэцүү байгаа ч гэсэн нэг сонирхлоор нэгдсэн залуучууд байдаг учраас манай бүтээгдэхүүнийг хүлээж авах үйлчлүүлэгчдийн хандлага маш сайн байдаг.

**Ж:** Хэдэн хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг вэ?

**Т.Зориг:** 12 хүн байгаагийн зургаагаас долоо нь мэргэжлийн дизайнер, бусад нь загварын чиглэлд сонирхолтой, маркетингийн чиглэлээр төгссөн хүмүүс байгаа.

**Ж:** Эрэгтэй ажил хэрэгч хувцас худалдан авч байгаа ихэнх хүмүүс гадаадаас авах хандлагатай байдаг ба үүнтэй өрсөлдөх тал дээр их анхаардаг байх гэж бодож байна. Энэ үнэн үү?

**Т.Зориг:** Дэлгүүр хэсэхэд авах сэтгэл ханамж гадаадын орнуудад илүү өндөр байдаг учраас хүмүүс ихэвчлэн гадаадаас ирэхдээ хувцас аваад ирдэг. Тэр таашаалаас өөр ямар таашаалыг авч болох вэ гэдгийг бид тооцож үзээд манай дэлгүүрт орж ирсэн үйлчлүүлэгч мэргэжлийн зөвлөгөө авч, мэргэжлийн имидж бүрдүүлэгчтэй болох боломжтой. Гадаадад очоод размер, үнэ гэх мэтийг худалдагчаас асуудаг бол манай дэлгүүрт орж ирээд VIP өрөөнд таны ажил, мэргэжил, хаана өмсөх гэж байгаа гэх мэт бүх л асуултуудын дагуу зөвлөгөө өгдөг онцлогтой. Зөвлөгөө өгдөг, мөн үндэсний үйлдвэрлэлээ дэмжих гэсэн сэтгэхүйтэй бизнесменүүд олон байдаг учраас гадны дэлгүүрүүдээс илүү биднийг сонгож байгаа. Үүнээс бид маш их урам авдаг.

**Ж:** Эрэгтэй ажил хэрэгч хувцаслалтад анхаарах хамгийн чухал зүйл юу байдаг юм бэ? Энэ тухай зөвлөгөө өгөөч.

**Т.Зориг:** Хувцас бол өөрийнхөө дотоод чанарыг илэрхийлж байгаа илэрхийлэл учраас зөв хувцаслалт нь орчин тойрноо хүндэтгэж байгаагийн нэг хэлбэр юм. Зөв хувцаслалт гэдэг нь та өөрөө хэн бэ, ямар настай, ямар ажил эрхэлдэг, хаана, хэнтэй уулзахдаа өмсөх гэж байгаа вэ, ямар орчинд байх вэ гэх мэт маш олон хүчин зүйлсээс хамаараад материал, өнгө, дагалдах цимэглэл нь өөрчлөгдөөд явахыг цогцоор нь шийдэж өгөхийг хэлнэ. Зөв хувцаслаж байгаа хүн тухайн цаг, мөчид өөрийгөө зөв илэрхийлж байна гэсэн үг.

**Ж:** Дүрэмт хувцас өмсөх ёстой ажил мэргэжил гэж байдаг. Гэтэл өөрийгөө илэрхийлэх ёстой гэж байна. Энэ хоёрын зөрүү нь юу юм бол?

**Т.Зориг:** Компанийн онцлог, дүрмээс шалтгаалаад дүрэмт хувцас өмсөх шаардлага гарна. Үйлчилгээний байгууллагад үйлчлүүлэгч орж ирээд нэг ижил үйлчилгээний мэдрэмжийг авах хэрэгтэй байдаг учраас ажилтан бүрээ ижилсүүлэхийн тулд дүрэмт хувцас өмсөх шаардлага тавьдаг. Гэтэл оффист суудаг, эсвэл сонирхолтой зүйл сэддэг хүмүүс өөрсдийгөө илэрхийлэх хувцсыг сонгодог. Том корпорацид ажиллаж байгаа хүн захирлынхаа нүдэнд өртөхийн тулд зөв хувцаслаж байгаарай гэж хүний нөөцийн хичээл дээр заадаг. Яагаад гэвэл хослол ихэвчлэн хоёр товчтой, энгийн захтай, хоёр халаастай гээд ерөнхий загвар нь төстэй байдгаас нэг оффист



ороход ижил загвартай хослол өмссөн залуус олон таардаг. Тиймээс өөрийн гэсэн имиджийг бүрдүүлэх хэрэгтэй гэж Америкт заадаг юм билээ.

**Ж:** Ярилцлагад орж байгаа хүнд хувцаслалт хэр чухал вэ?

**Т.Зориг:** Америкт хүний нөөцийн багш нар ажлын ярилцлагад орохдоо хувцаслалт болон ярианы өнгөн дээрээ анхаарах ёстой гэж заадаг. Яагаад гэвэл эхний 1-2 минутад төрдөг анхны сэтгэгдэл нь таны хувцаслалт, үс засалт, хоолойны өнгө болон алхалтанд тулгуурлаж ажилд авах эсэхээ 50 хувийг нь шийдчихдэг. Тухайн компанийн соёлд тохирох эсэх нь тухайн хүний биеэ авч яваа байдлаас харагддаг гэж үздэг.

**Ж:** Тэгэхээр зөв хувцаслалт гэдэг нь таны хүсэл, бодол биш, амьдрахад хэрэгтэй шаардлагуудын нэг болчихсон байна. Ямар төрлийн хувцас өмссөн хүн аятайхан харагддаг вэ?

**Т.Зориг:** Асуудал нь брэнддээ биш. Хэд хэдэн инээдтэй дүрэм байдаг. Тухайлбал хэзээ ч боссоосоо гоё хувцаслаж болохгүй, ярилцлагад хэтэрхий ганган хувцаслаж болохгүй гэх мэт. Үүнээс гадна зөвхөн өөртөө таарсан хувцсыг өмсөх ёстой. Учир нь эрэгтэй хүн тухгүй хувцас өмссөн байвал биеэ барьдаг, хөлөрдөг, ямар нэг зүйл оролдоод байдаг гэх мэтээр ярилцлагад орох, өөрийгөө илэрхийлэхэд нь сөргөөр нөлөөлдөг байна. Тийм учраас өөртөө таарсан хувцас, хослол өмссөн тохиолдолд өөртөө итгэлтэй болчихдог. Хэдий үнэтэй байсан ч таараагүй бол муухай харагддаг.

**Ж:** Эрэгтэй хүний цамц нь гараа унжуулаад зогсож байхад пиджакныхаа ханцуйнаас урт байх ёстой гэдэг. Цамц хэр зэрэг урт байвал тохирсон гэж үзэх вэ?

**Т.Зориг:** Хослол гэдэг бол эрэгтэй хүний хувцасны шүүгээнд 120 жил болж байгаа буюу хамгийн удаж байгаа зүйл юм. Цамц нь зогсож байхад 1-2 хуруу илүү гарсан байх ёстой. Пиджакны ханцуй нь бугуйны яс заавал давсан байх ёстой. Эрхий хуруу, бугуй нийлсэн хээгт пиджакны ханцуй байхад таарсан цамц бага зэрэг урт гараад ирнэ.

**Ж:** Үүнийг сургуульд зааж өгдөг болвол яасан юм бэ?

**Т.Зориг:** Хувцаслалт гэдэг бол тухайн хүнийг илэрхийлж байгаа илэрхийлэл, харин хослол гэдэг бол тухайн нийгмийг гадныханд харуулж буй илэрхийлэл. Зөв хувцаслах, зөв хооллох, ширээний соёл гэх мэт олон улсын стандартаар мөрддөг дүрмүүдийг хичээлээр зааж өгвөл зөв байх гэж бодож байна.

**Ж:** Ямар үед эрэгтэй хүн хантаазтай хослол өмсөх хэрэгтэй байдаг юм бэ?

**Т.Зориг:** Хантааз гэдэг бол анх хослол үүссэн цагаас хойш байсан зүйл тул үүнийг яг бүрэн хувцаслалт гэж ойлгож болно. Сүүлийн үед хантаазгүй өмссөн ч зөв

хувцаслалтад тооцогдож байгаа нь загвар өөрчлөгдөж байгаагийнх юм болов уу.

**Ж:** НҮБ, элчин сайдын яамдууд юмуу дипломат үйл ажиллагаан дээр "Business casual" гэсэн байдаг. Энэ юу гэсэн үг вэ?

**Т.Зориг:** Casual гэхээр зангиагүй гэж үзэж болно. Formal гэх юм бол заавал хослолтой байх ёстой. Тэрнээс гадна "Black tie" гэж байдаг дээр нь заавал Tuxedo буюу хар өнгийн, зах нь торготой гоёлын смокинг байна. Мөн өмд нь cut-тай, cut-гүй гэж байх бөгөөд түүн дээр зохицох лакан гутал гэж байна. Англичууд бол бидний яриад байгаа Tuxedo буюу смокингоо "Dinner jacket" гэж нэрлээд шувуу шиг хормойтой фрагийг хүндэтгэлийн ёслолд хэрэглэдэг. "Morning coat" гэж байгаа, тэр нь саарал өмд, цайвар шаргал юмуу саарал өнгийн зөрсөн хантаазтай, пиджак нь хойноо урт байдаг.

**Ж:** Фраг нь бусад оронд яаж хэрэглэгддэг вэ?

**Т.Зориг:** Фраг бол илүү дуурь, тоглолт зэрэгт өмсдөг буюу мэргэжилтэй илүү холбоотой. "Morning coat"-ийг нар жаргаагүй байхад болж байгаа хүлээн авалтад өмсөнө.

**Ж:** Та Италийн үнэтэй брэндтэй хамтарч ажиллаж байна. Тэдэнтэй яаж танилцсан түүхээсээ хуваалцаач.

**Т.Зориг:** Манай зах зээл жижигхэн учраас гадны зах зээлүүд өөрсдөө орж ирэх биш "franchise partner" хайж явдаг. Хүн амын тоо бага, энэ чиглэлээр өрсөлдөж байгаа компаниуд цөөхөн учраас тэр компани руу хүсэлт явуулж байгаа нь бараг ганцхан би л байгаа юм. Тэгэхээр энэ залуу монголдоо өөрөө эрсдлээ хүлээгээд бизнесээ хийе гэж байгаа юм чинь зөвшөөрөл олгоё гэсэн байдлаар бизнесүүд ханддаг. Би тэр чиглэлд нэлээн сонирхолтой учраас сайн судалгаа хийж байгаад ISAIA гэдэг брэндийг монголд оруулж ирсэн.

**Ж:** Итали шиг хэцүү зах зээлд их амжилттай яваа брэнд байна лээ. Та маркетинг талдаа яаж анхаардаг вэ?

**Т.Зориг:** Эрэгтэй хүн нэг юмандаа үнэнч байдаг учраас их сонин худалдан авалттай. Тиймээс чанартай бүтээгдэхүүн оруулж ирснээрээ энэ хэрэгцээг нь хангаж өгч байгаа юм.

2017. 11. 03

### Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/t-zorig-zorig-tumennasan> холбоосоор үзнэ үү.


Татгалзахын аргагүй САНАЛ

FORD EXPLORER | JAGUAR F-PACE | RANGE ROVER

1-2 ton FUEL | WINTER TIRE | TRAVEL VOUCHER | SERVICE

TEL: 99118301, 99106507, 99118375  
www.waa.mn

WAGNER ASIA AUTOMOTIVE LLC





## НИЙТЛЭЛ

ДЭЛГЭРИЙН УЯНГА  
Өмгөөлөгч, хууль зүйн доктор

# ХУУЛЬ ХЭРЭГГЭДЭГ НИЙГЭМ БА ЭМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР

"Монголд зарж буй эм, эмнэлгийн хэрэгслийн гуравны нэг нь хуурамч. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын судалгаагаар Монгол улсад зарагдаж буй нийт эмийн гучаад хувь нь чанаргүй буюу бүртгэгдээгүй байдаг ажээ." / Д.Жаргалсайхан, "Эрүүл биш эрүүл мэндийн тогтолцоо", **Дефакто Газет № 24**

Орчин цагт Дэлхийн Худалдааны Байгууллагын (ДХБ) наад захын стандартыг хангасан оюуны өмчийн хэрэгжилтийн тогтолцоо нь хуурамч эмтэй тэмцэж, эмийн чанарыг хангаж, улмаар нийтийн эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай юм.

Монгол Улс нь 1997 онд ДХБ-ын гишүүн болсон. ДХБ-ын (ТРИПС-ийн хэлэлцээр) наад захын шаардлагыг хангасан тогтолцоог бүрдүүлэх анхны алхмыг 2002 онд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баталснаар хийсэн. Тус шинэчлэлийг том амжилт гэж тухайн үед үнэлж байсан бөгөөд гадны мэргэжилтнүүд монголыг бусад шилжилтийн улсуудын хувьд үлгэр жишээ болох шинэчлэл хийлээ гэж магтан сайшааж байв. Тус хууль нь шүүхийн практикаар хөгжүүлэх боломжтой, оюуны өмчийн хэрэгжилтийг хангах хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зохицуулалтыг агуулдаг.

Өдгөө арван таван жилийн дараа шүүхэд хандах замаар оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг хангах нь амьдралд ач холбогдолгүй хэвээр байна. Үүний оронд социализмын үе шиг төрийн байцаагчдын оролцоотойгоор хууль сахиулах хуучирсан арга баримтласаар байгаа ба энэ нь амьдрал дээр оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх цорын ганц арга зам юм.

Төрийн байцаагчдын (гүйцэтгэх засаглалын) оролцоотойгоор оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлдэг одоогийн тогтолцоо нь эрх зүйт төрийн (rule of law) наад захын шаардлагыг хангадаггүй, бодит үр дүн муутай, монголын төр болон оюуны өмчийн эрх эзэмшигчдэд (эмийн бүтээгдэхүүний хувьд патент, барааны тэмдэг эзэмшигчдэд) өндөр өртөг, зардлыг үүрүүлдэг тогтолцоо юм.

Тодруулбал, одоогийн тогтолцоо нь, нэгдүгээрт, Засгийн газрын агентлагийн дарга нарыг орчин цагийн "тайж нар" болгодог. Жнь: барааны тэмдгийн зөрчил гарах (хуурамч эмийг оригинал эмийн баглаа боодолд хийж зарах) үед барааны тэмдэг эзэмшигч (оригинал эмийн үйлдвэрлэгч) нь оюуны өмчийн эрхийн асуудал эрхэлсэн ЗГ-ын агентлагт зөрчлийг таслан зогсоох хүсэлт тавьж, эхлээд төрийн захиргааны байгууллагын байцаагч, дарга нарын царайг харах ёстой болдог. Монголын төрийн захиргааны байгууллагууд нь захирах, захирагдах ёсны зарчимд тулгуурласан засаглалын пирамид тогтолцоотой. Аливаа шийдвэрийг даргын зөвшөөрлөөр гаргадаг.

Асуудал нэгэнт хурцадсан үе шатанд буюу барааны тэмдэг эзэмшигч нь ЗГ-ын агентлагт хандаад ямар нэг дорвитой үр дүн гараагүй, эсвэл барааны тэмдэг эзэмшигч болон аливаа гуравдагч этгээдэд (болон зөрчил гаргасан гэх этгээдэд) эд хөрөнгийн хохирол учирсан бол шүүхэд хандах практик, тогтолцоо байдаг.

Энэхүү төрийн байцаагчийн хяналт нь шүүгч бие даан (даргын заавраас хараат бус байдлаар) хууль ба бодит фактыг үнэлж, хэрэглэх замаар оюуны өмчийн зөрчлийг хэрхэн, яаж таслан зогсоохыг нэн даруй тогтоож, гүйцэтгүүлдэг дэлхий даяар нийтлэг байдаг ДХБ-ын шаардлагыг хангасан тогтолцоотой харьцуулах боломжгүй, тамга барьсан түшмэдээс хараат болхи тогтолцоо юм.

Хоёрдугаарт, оюуны өмчийн хэрэгжилтийг төрийн байцаагчид хангах тогтолцоо нь ДХБ-ын (ТРИПС-ийн хэлэлцээр) шударга процессын шаардлагыг хангадаггүй. Патент (техникийн шинэ бүтээлийн эрх, жнь: шинэ эмийн жор) болон бүтээгдэхүүний нэрийн

эрх (барааны тэмдэг, жнь: шинэ эмийн нэр) олгоход Оюуны өмчийн асуудал эрхэлсэн ЗГ-ын агентлаг нь материаллаг шаардлага (жнь: шинэ байх шаардлага) болон бичиг цаасны бүрдлийн шаардлагыг хангасан эсхийг шалгаж оюуны өмчийн эрх олгодог. Монголд оюуны өмчийн газар нь оюуны өмчийн зөрчлийг таслан зогсоох шүүх, прокурор лугаа адил эрх мэдэлтэй. Ийнхүү өмчлөх эрх олгосон, бүртгэл хийдэг захиргааны байгууллага өөрөө оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг хангах нь анхнаасаа ашиг сонирхлын зөрчил бий болгодог. Энэ тогтолцоонд жнь: зөрчил гаргасан гэх хүн анхнаасаа л "сул тал" болдог тул тогтолцоог буруугаар ашиглах боломжтой (оюуны өмч бол зах зээлийн өрсөлдөөний хэрэгсэл учир төдий хэмжээгээр буруугаар ашиглах боломжтой гэдгийг энд ухамсарлаж ойлгох учиртай).

Гуравдугаарт, одоогийн монголын оюуны өмчийн хэрэгжилтийн тогтолцоо нь төр, татвар төлөгчдөд ихээхэн өндөр өртөгтэй тогтолцоо юм. ЗГ-ын агентлаг бүр өөрийн хариуцсан хуультай, түүнийгээ хэрэгжүүлэх өөрийн дүрэм, журамтай байдаг. Жнь: барааны тэмдгийн зөрчил гарах үед Оюуны өмчийн газар, Гаалийн Ерөнхий Газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар, Эрүүгийн цагдаа гэх мэт газруудад хандах боломжтой байдаг. Олон газар нэг зөрчлийг хариуцах хуулийн боломж нь эдгээр төрийн байгууллагуудын хооронд эрх хэмжээний тодорхойгүй байдал бий болох эсвэл нэг нь нөгөөгөөс бичиг цаас, тодорхойлолт шаардах гэх мэт шалтгаанаар эрхийн хамгаалалтыг нэн даруй хангахад саад болох боломжтой.

Цаашид өмчийн эрх, үүний дотор оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг шүүхийн журмаар шууд хангуулдаг ДХБ-ын жишгийг хангасан тогтолцоо монголд хэрэгтэй байна. Гүйцэтгэх засаглалд хамаарах ЗГ-ын агентлагууд эрх хэрэгжүүлдэг тогтолцооноос шүүхийн журмаар эрх хэрэгжүүлдэг тогтолцоонд шилжих шаардлагатай. Энэ шилжилт нь монголын хувьд хялбар зүйл биш. ДХБ-ын (ТРИПС-ийн хэлэлцээрийн) шаардлагыг хангах иргэний шүүхийн процессын талаар мэдлэг, туршлага монголд байхгүй байна. Энэ мэдлэг, туршлагагүй байдал нь эргээд оюуны өмчийн эрх эзэмшигчид болон оюуны өмчийн зөрчил гаргасан гэх хүн, байгууллага шүүхээр эрх ашгаа хамгаалуулахад саад болж, хууль хэрэгжүүлэх салбарт гүйцэтгэх засаглал (дарга, байцаагч) давамгайл байр суурьтай байж, үүнээс үндэслэн төрийн захиргааны байгууллагын шатанд ашиг сонирхлын зөрчил бий болох хөрс, суурь болж байна. Гэхдээ монголын шүүх ч гэсэн улс төр, бизнесийн явцуу нөлөөллөөс хамгаалагдаагүй гэдгийг онцлох хэрэгтэй (жнь: эмийн худалдаа нь өндөр ашигтай, том бизнес гэдгийг сануулахад илүүдэхгүй). Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч нь олон тэрбум төгрөг үрсэн сонгуулиар гарч ирж, сонгогддог (Д.Жаргалсайхан, "Сүүлчийн Ерөнхийлөгч", **Дефакто Газет № 04**), Ерөнхийлөгч нь бодит байдал дээр монголын шүүхийн дарга бөгөөд шүүгчийг сонгон шалгаруулж, шүүгчид сахилгын хариуцлага оногдуулахтай холбоотой эрх мэдэлтэй Шүүхийн Ерөнхий Зөвлөл нь хараат бус байгууллага бус, харин социализмын үед байсан Шүүх Яамтай ойролцоо байгууллага юм гэдгийг гэдгийг **Дефакто Газет № 14**-т гарсан нийтлэлдээ харьцуулж, харуулсан билээ ("Монголын шүүх: Барын амнаас гараад арслангийн аманд орохуй").

Эцэст нь дүгнэхэд, зах зээлийн эдийн засаг, эрх зүйт төрийн тогтолцооны шилжилтийн үйл явц монголд дуусгавар болоогүй байна. Зах зээлийн эдийн засгийн зохицуулалтын нэг хэлбэр бол бизнес эрхлэгчид өөрсдөө оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг хараат бус шүүх, шүүгчээр хангуулах замаар хууль бус худалдаа, наймаанаас зах зээл, хэрэглэгчийг хамгаалдаг явдал юм. Монголд одоогоор ийм тогтолцоо байхгүй байгаа учир иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах нэг хүчтэй зэвсгийг хэрэглэхгүй байна гэсэн үг юм.





## ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2017.12.24-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://fargaldefacto.com/category/12>

# УИХ-ЫН ГИШҮҮДИЙН БҮРЭН ЭРХ

УИХ-ын гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэн шалгах эрхтэй боллоо. Зарим иргэдийн гомдлын дагуу Үндсэн хуулийн цэцийн хуралдаан болсон бөгөөд УИХ-ын гишүүдийг энгийн иргэдтэй адилхан шалгаж болох эсэхийг хэлэлцэж шийдвэрлэлээ. МУ-ын Их хурлын тухай хуульд зааснаар гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан тохиолдолд л зөвхөн шалгаж болохоор заасан байсныг өөрчиллөө. Энэхүү заалт нь тэгш эрхийн зарчмыг зөрчиж байсан юм.

Энэ шийдвэрт өөрийн бодлоо хэлэхээс өмнө зарим нэг УИХ-ын гишүүд юу гэж хэлж байсныг эргэн санацгаая. Ц.Нямдорж гишүүн цэцийн саналыг хүлээн авах хэрэгтэй гэж хэлсэн бол Лу.Болд гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол шалгагдах ёстой гэсэн, Х.Нямбаатар гишүүн хэлмэгдүүлэхийн л эсрэг байх ёстой шүү гэсэн, Г.Тэмүүлэн гишүүн цаг үедээ таарсан шийдвэр гэж хэлсэн байна. Ц.Даваасүрэн гишүүн хэлэхдээ цэцийн гишүүд буюу нэн ялангуяа Д.Сугар гишүүн өөрөө гэмт хэрэгтэн хэрнээ халдашгүй эрх эдэлж суучихаад биднийг ингэж дарамталсан хууль гаргах ёсгүй гэж хэлж байгаа юм. Энэ бүх хүмүүсийн хэлсэн зүйлийг том зургаар харвал шударга

ёсны асуудал босож ирнэ. Өнөөдөр монголын иргэд шударга ёсыг хүлээж байгаа буюу тэр дундаа энэ ёсыг хуульчилдаг хүмүүсээс энэ ёсыг хүлээж байгаа.

Намын санхүүжилт нууц учраас улс төрийн намууд төр, ард түмэн хоёрыг холбохын оронд төр, нууц бүлэглэлийг холбоод демократура бий болсон байна. Үүнд харьяалагдахгүй хүн бол гагцхүү С.Жавхлан гишүүн л байх. Бусад 75 гишүүд нэгэнт өөрсдийн намын санхүүжилтийг ил болгож чадахгүй юм чинь шударга ёсыг тогтоож чадахгүй гэдэг нь институтын хэмжээнд батлагдаж байна. Энэ ганц манайд ч бус ер нь пост социалист орнууд буюу нийтийн өмч нь давамгайлж байсан орнуудад бий болж байгаа ч манайд их тодорхой илэрч байна. Төр засаг нь улс төрийн намуудаар дамжин ард түмэндээ бус хэдхэн бүлэг хүмүүст үйлчилдэг боллоо гэсэн үг л дээ. Ингээд үзэхээр Монгол улсад шударга ёс дутагдаад байгаа учраас өнөөдөр бид их хурлынхаа түвшинд хүртэл яриад гэмт хэрэг хийхээ болиоч ээ гэж байна. Одоо байгаа улсын их хурлын гишүүд намын санхүүжилтийн тухай хуулийг хэлэлцэхгүйгээр шударга болно гэж бодохгүй байна, хэлэлцэнэ ч гэж бодохгүй байна.

# ОУВС БА МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ

ОУВС монголын эдийн засгийг хурдан сэргэж байна гэж дүгнэлээ. Валютын сангийн захирлуудын зөвлөлөөр Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн 1, 2 дугаар шатны үнэлгээг энэ сарын 15-ны өдөр баталсан. Нэйл Сакерын мэдэгдсэнээр монголын эдийн засаг санаснаас хурдан сэргэж байгаа бөгөөд эерэг үр дүнгүүд гарч байна гэж дүгнэлээ. Учир нь уг хөтөлбөрийн бүх зорилтууд давж биелжээ. Бүтцийн шинэчлэлийн үйл ажиллагаанууд ч сайн байна гэж дүгнэжээ.

Эдийн засаг сэргэж байна гэж ярьсан ч би хувьдаа эдийн засаг сэргэсэн гэж бодохгүй байна. Мэдээж ОУВС монгол руу хямдхан зээл оруулж, бид үнэтэй зээлээ түүгээрээ төлөөд яваад байгаа учраас монгол хэмээх саванд байгаа долларын нөөц нэмэгдэж үүнтэй холбоотойгоор төгрөгийн ханш тогтворжиж байгаа юм. Энэ бол мэдээж сайхан мэдээ. Гадаад валютын нөөц 2.5 тэрбум доллар болсон ч МУ-ын гадаад валютын нөөц зээлээр бий болсон гэдгийг мартаж болохгүй.


Эдийн засаг сэргэх дээр юуны өмнө хувийн хэвшил сэргэсэн үү гэдгээс асуух хэрэгтэй. Хувийн хэвшил сэргээгүй, МУ-ын ЗГ хувийн хэвшлийг дарамталж байгаа. Гайгүй мэдлэг чадвартай хүн нэг сая таван зуун мянгаас дээш төгрөгний цалин авбал 25 хувийг нь авна гэж байгаа. Үүнийг нь ч ОУВС яагаад ч юм дэмжээд байгаа. Хэрвээ ингээд 25 хувийг нь авъя гэвэл долоо хоногийн дараагаас хүмүүсийн цалин эрс буурна. Татварын орлого нь ч бүр буурна. Цалин биш өөр байр, машин хэлбэрээр ажилтнаа алдахгүйн тулд цалинжуулж ажиллах байх. Эдийн засаг сэргэнэ гэдэг нь хувийн компаниуд идэвхтэй болоод хүмүүсийг ажилд аваад явахыг хэлдэг.

Банкны зээл буураагүй. ОУВС-ийн гэрээний нөхцлийн дагуу банкны активыг үнэлэх явц дууссан. 12-р сарын 15 гэхэд бүх банкуудын активын үнэлгээний тайлан хараат бусаар Монголбанкнд хүргэгдсэн байгаа. Өмнөд Солонгос улс 1998 онд яг ийм байдалд ороод яг ийм хөтөлбөрт хамрагдан, яг ингэж активын үнэлгээ хийлгээд 20-оод банкнаас дөрвөн банктэй үлдсэн. Бусдыг нь сэргээж босгох тухай тусдаа төрийн активын компани бий болгоод түүгээрээ зөв менежмент хийгээд хямралаас гарсан. Манайх тэгэж чадах эсэх дээр нэлээд өндөр алхам биднийг хүлээж байна. Хэрэв энэ маягаар банкуудаа чанаржуулж чадахгүй бол банкууд нь хадгаламж эзэмшигчдийн мөнгөөр Эрдэнэтийг авсан шиг зарцуулаад байвал харин байдал улам хүндэрнэ. Банкуудын өөрийн хөрөнгийг томруулах асуудал явагдаж байгаа, эрсдлийн сангаас муу зээлүүдийг хаах асуудал байгаа ба энэ бүхэн аль зэрэг ил тод, зоригтой явахыг Монголбанкны Ерөнхийлөгч мэдэх ёстой.

Шударга ёс байхгүй учраас шударга өрсөлдөөн байхгүй байна. Шударга өрсөлдөөн байхгүй учраас хувийн компанийн хувьд бизнес хийх сонирхолгүй байгаа. УИХ-ын гишүүд чинь монголын хамгийн том компаниудын эзэд байх юм байна шүү дээ. Хажуугаар нь маш их алдагдалтай төрийн өмчийн компаниуд байгаа. Төрийн өмчийн компанийн алдагдлыг төсвөөс санхүүжүүлж байгаа шүү дээ. Гэтэл хэчнээн хүүхэд сургуульгүй, хэчнээн өвчтөн эмнэлэггүй байгаа билээ.

*Таны цалингаар зөвхөн таны гэр бүл амьдардаггүй, та энэ олон дарга нарын зардлыг дааж байдгаа битгий мартаарай.*

# ХӨШИГТИЙН ХӨНДИЙН НИСЭХ БУУДАЛ



Гэрэл зургийг nubia.mn

Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал ИНЕГ-ын шалгалтын нислэгийн баг туршилтын нислэг хийсэн. Энэхүү шалгалтын нислэг нь ОУ-ын иргэний нислэгийн шаардлагын дагуу хийгджээ. Энэхүү шалгалтын нислэг хийгдсэнээр буулт хийх ILS, зай хэмжих DME төхөөрөмжүүдийг ашиглан аюулгүй буулт хийхэд бэлэн болсныг харуулж байгаа юм байна.

Өнөөдөр Чингис Хаан олон улсын нисэх буудал жилд нэг сая зорчигч л авдаг, харин Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал ашиглалтад орсноор энэ тоо гурван саяд хүрнэ. Нисэх буудлын хувьд бол барьчихсан, зам нь л дутуу байгаа. Энэ нисэх буудлыг Япон улсын зээлээр 600 сая ам.доллараар 40 жилийн 0.1 хувийн хүүтэй байгуулж байгаа. Нисэх буудал бэлэн болоход хоёр төрлийн шалгалт хийгддэг. Нэг нь бууж суухад нь ямар үйлдэл хийж болох

вэ, нөгөө нь тоног төхөөрөмжийн хувьд бүрэн болж байна уу гэдэг юм. Өнгөрсөн долоо хоногт тоног төхөөрөмжийн шалгалт л хийгдсэн.

Энэ нисэх буудлыг Японы консорциум, монголын ЗГ хамтран удирдана. Япон 51 хувийг удирдаж 30 жил менежмент хийнэ. Японы консорциумд Мицубиши, Ханайда, Нарита зэрэг Токиогийн хоёр том нисэх буудал байгаа юм. Мөн Жалүкс буюу Японы газрын үйлчилгээний компани байх юм байна. Энэ нь Нөү Хау-ийн хувьд бол Японы стандарт орж ирж байгаа хамгийн чухал алхам. Мөн Хятадаас 500 сая ам.доллар зээлээд гурван чиглэлээр зам тавих ба түүний нэг нь 35 км буюу яармагаас нисэх буудал хүртэлх зам тавьж байгаа. Замаа тавих гэтэл 140 гаруй аж ахуй нэгжийн газар дээгүүр дайрах тул удааширсны эцэст сая л шийдэгдсэн. Одоо бол зам тавих чөлөөтэй болсон тул 4-р сард эхэлнэ. Онгоц өөрөө 1200 га газар, түүнийг тойроод 10 дахин том буюу 12000 га газар онгоцны буудлын зориулалттай түр ашиглана гэсэн ЗГ-ын шийдвэр 2010 онд гарсан юм байна. Гэтэл 2014 онд Сэргэлэн сумын засаг дарга 500 га газрыг нь нэг компанид өгчихсөн байгаа юм. Энэ хоёр хоорондоо газрын асуудлаар марган гурван шатан дээр ЗГ-ын буруу болчихсон. Нисэх буудал чинь буудлаасаа гадна тойроод олон байгууламж байх ёстой л доо. Тэгтэл ингээд газрыг нь өгөхгүй байгаа юм.

Үүнд мөн нэг анхаарах зүйл бол МИАТ-ийг хувьчлах асуудал юм. МИАТ-ийг хувьчлахгүйгээр олон онгоц ирэхгүй. МИАТ өөрөө монополь нислэг хийдэг учраас тэр юм.

# БОДЛОГЫН ХҮҮГ БУУРУУЛЖЭЭ



Гэрэл зургийг news.mn

Монголбанкны бодлогын зөвлөл бодлогын хүүг нэг хувиар бууруулж 11 хувь болгожээ. Үндсэн шалтгаан нь бизнесийн идэвхжлийг дэмжих, ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх гэсэн байна. Мөн макро эдийн засгийн эрсдлүүд буурсантай холбоотой гэжээ.

Бодлогын хүүгээ энэ оны эхээр бууруулах хэрэгтэй байсан гэж бодож байна. Бүр оройтлоо гэхэд л хавар буулгах хэрэгтэй байсан болов уу. ЗГ, Монголбанк хоёр мөнгө авчихдаг хоёр том институт яваад байна. Монголбанкаа дарамталж байгаад ЗГ бүх мөнгийг нь аваад юу ч үлддэггүй байлаа шүү дээ. Засгийн газар хөнгөлөлттэй зээл аваад Монголбанкнаас мөнгө авахаа болихоор буурах нь аргагүй. Засгийн газар Монголбанк хоёр уялдаатай.

Монголбанкинд хэдэн арга зам байдгийн нэг нь бүх арилжааны банкны заавал байлгах ёстой албан нөөц юм. Бүх иргэд, байгууллагын

хадгаламж харилцах зэрэг дансанд байгаа үлдэгдлийн 13 хувиар Монголбанкны харилцах дансанд байршуулах ёстой байдаг. Мэдээж инфляци үүсч болзошгүй буюу Монголбанк 5 хувь байсан инфляци 8 хувь боллоо гэж хэлж байгаа. Энэ хүүгээ хэтэрхий багасгавал мөнгө эдийн засаг руугаа ороод эхэлмэгц инфляци ихэсдэг. Инфляци ихсэхээр ямар ч агуулгагүй байгаа юм л даа. Мөнгөө хүмүүс хадгаламжид хийхдээ ядаж инфляциасаа илүү мөнгө олъё гэж бодож байгаа. Инфляци гэдэг чинь алдагдсан боломж байхгүй юу. Бид 14 хувийн хүүтэйгээр мөнгөө хадгаламжид өгч байгаа ч үнэн хэрэгтээ 6 хувийн л ашиг болж байгаа. Учир нь 8 хувь нь үнэгүйдсэн байгаа юм.

**Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.**

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh17-12-24> холбоосоор үзнэ үү



NEW NISSAN **PATROL**



☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

**ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:**

Урьдчилгаа **0%**  
Хүү **1.4%**  
Хугацаа **84** сар

**УРАМШУУЛАЛ:**



**ҮНЭ: ₮214.0 сая**





## JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл  
[www.jargaldefacto.com](http://www.jargaldefacto.com) болон [www.defacto.mn](http://www.defacto.mn) вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

### РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан  
Дангаасүрэнгийн Энхбат

### ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа  
Баг: Батхүүгийн Амар  
Отгонсүрэнгийн Билгүүн  
Өсөхбаярын Биндэръяа  
Адъяагийн Тунгалаг

### ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com  
☎ +976 94109342  
🌐 www.defacto.mn